



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар 09/03

Арвайхээр сум

Төлөөлөгчдийн хурлын тухай
оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2025 онд 20, 2026 онд 30, 2027 онд 30, 2028 онд 20 хувийг тус тус хэрэгжүүлэхээр тооцон, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2025 оны нэгдүгээр улиралд багтаан баталж, аймгийн хөгжлийн жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Пүрэвдорж)-д даалгасугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ



222401112



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 22 дугаар сарын 03-ний өдрийн
02/03 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1.УЛСЫН БҮСЧЛЭЛ-ХАНГАЙН БҮС

Бүс нутагт амьдрах таатай нөхцөлийг бий болгож, тээвэр логистикийн оновчтой сүлжээг байгуулан, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангана.

1.1.1.Улс болон бүсийн чанартай босоо, хэвтээ тэнхлэгийн авто замын сүлжээг байгуулж, тээвэр ачаа эргэлтийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1.1.1. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто замаас Өвөрхангай нутагт хамаарах 150км авто замыг барина.
- 1.1.1.2. Арвайхээр-Баянгол-Сайхан Овоо-Мандал Овоо чиглэлийн 230км авто зам барих ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, эхлүүлнэ.
- 1.1.1.3. Арвайхээр-Шивээхүрэн боомтын чиглэлийн 336км авто зам барих ажлын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, эхлүүлнэ.

1.1.2. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон мега төсслүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн зүгээс ажиллах хүч, техник хэрэгсэл, шаардлагатай бараа материалыг нийлүүлэх замаар аймгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1.2.1. Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь судалгаа, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажилд орон нутгаас хамтран ажиллаж, эхний ээлжийн бүтээн байгуулалтын ажилд оролцно.
- 1.1.2.2. Шинэ Хархорум хотын усны хэрэгцээг хангах болон.govийн бүсийн хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хангах зорилгоор Орхон-Онги төслийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.2.3. Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ хүчдэлийн 2 хэлхээт 287км цахилгаан дамжуулах агаарын шугам, 2x63 мВт чадалтай дэд станц байгуулна.
- 1.1.2.4. Бүсийн болон баруун бүсийн эрчим хүчийг тэтгэх зорилго бүхий цахилгаан станцыг Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

1.2.ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ДЭД ТӨВ

Аймгийн нутаг дэвсгэрийг Арвайхээр, Хархорин, Есөнзүйл, Сант, Гучин-Ус төвтэй таван дэд бүсээр бүсчлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.1.Арвайхээр төвтэй Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Тарагт, Уянга, Хайрхандулаан сумдыг хамарсан “Төвийн бүс”-ийг тээвэр логистик, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.2.1.1. Арвайхээр-Тарагт-Уянга чиглэлийн 50 км авто зам, Арвайхээр-Зүүнбаян Улаан чиглэлийн 38 км авто зам, Улсын чанартай А0302 авто замаас Баянтээгийн уурхай хүртэлх 22 км авто замуудыг “Нутгийн зам” төслийн хүрээнд барьж эхлүүлнэ.
- 1.2.1.2. Улсын чанартай босоо, хэвтээ тэнхлэгүүдийг түшиглэн “Хангайн бүс”-ийн (Баянхонгор Өвөрхангай, Архангай) бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамж, үйлдвэрлэл үйлчилгээ, тээвэр логистикийн төвийг байгуулна.

- 1.2.1.3. Арвайхээр хотод үйл ажиллагаа явуулж байгаа мах, сүү, ноос, арьс, шир боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг савхи, савхин эдлэл үйлдвэрлэх, ноос ээрэх, ноолуур угаах, самнах чиглэлээр өргөтгөнө.

- 1.2.1.4. Таталцах сумдад хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж, төв суурин газарт нийлүүлэх загвар аж ахуйг дэмжинэ.

1.2.2.Хархорин төвтэй Хужирт, Бат-Өлзий сумдыг хамарсан “Хойд бүс”-ийг аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.2.2.1. Дэд бүсэд рашаан сувилал, адал явдалт, түүх соёл, археологийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.2.2.2. Улсын чанартай А0301 авто замаас Хужирт сум хүртэлх 43.3км авто замын сүлжээг байгуулж, бусад дэд бүсүүдтэй холбох болон Бага Илэнх-Арвайхээр-Шивээхүрэн чиглэлийн эдийн засгийн босоо коридорын эхлэлийг тавина.
- 1.2.2.3. Хужирт-Бат Өлзий чиглэлийн 49км хатуу хучилттай авто замыг барьж, ашиглалтад оруулна.
- 1.2.2.4.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулж, төв суурин газруудыг бүтээгдэхүүнээр хангана.

1.2.3.Есөнзүйл төвтэй Бүрд, Өлзийт сумдыг хамарсан “Зүүн бүс”-ийг уламжлалт мал аж ахуй, мах сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй, түүх соёлын аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.2.3.1. Улсын чанартай А0301 авто замаас Есөнзүйл хүртэлх 14.7км, Бүрд сум хүртэлх 18км, Өлзийт сум хүртэлх 20км авто замуудыг “Нутгийн зам” төслийн хүрээнд барьж эхлүүлнэ.
- 1.2.3.2. Малын тэжээл тариалах, мах сүүний эрчимжсэн аж ахуй, малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ.
- 1.2.3.3. Бүрд сумын нутаг дахь Монгол орны Төв цэг, Ширээт цагаан нуур, Өлзийт сумын нутаг дахь Сангийн далай, Есөнзүйл сумын нутаг дахь Өндөр гэгээний Өвгөн суварга, Сэргүүн булаг зэрэг байгалийн болон түүхэн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлж, Орхоны хөндий болон товийн бүсийн аялал жуулчлалын маршруттай холбоно.

1.2.4.Сант төвтэй Баянгол, Баян-Өндөр сумдыг хамарсан “Урд бүс”-ийг Арвайхээр-Чойр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто замыг түшиглэн

уламжлалт мал аж ахуйгаас бэлтгэгдэх бүтээгдэхүүнийг Өмнөговийн уул уурхайн зах зээлд нийлүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.2.4.1. Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замаас Сант сум хүртэлх 10км авто замыг “Нутгийн зам” төслийн хүрээнд барьж эхлүүлнэ.
- 1.2.4.2. Уламжлалт мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ.
- 1.2.4.3. Малыг үйлдвэрийн аргаар төхөөрч, хадгалж, зах зээлд нийлүүлэх жижиг аж ахуйг дэмжинэ.
- 1.2.4.4. Орхон-ОНГИ төслийн Өвөрхангай аймагт хамаарах бүтээн байгуулалтын ажилд ажиллах хүч, шаардлагатай хүнс, өргөн хэрэглээний бараа материалыг нийлүүлэх замаар бүсийн эдийн засгийг тэтгэнэ.

1.2.5. Гучин-Ус төвтэй Богд, Төгрөг, Баруунбаян-Улаан сумдыг хамарсан “Говийн бүс”-ийг Бага Илэнх-Шивээхүрэн чиглэлийн Улсын эдийн засгийн босоо коридорыг түшиглэн хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.2.5.1. Улсын чанартай А0302 авто замаас Гучин-Ус, Богд сум хүртэлх 172км авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ.
- 1.2.5.2. Хүрэн хадны рашаан, элсний сувилал, Арц богдын нуруу, Зүүнбогд уул, Өөш шахлага зэрэг байгалийн болон палеонтологийн дурсгалт газруудыг түшиглэн тусгай сонирхлын аяллыг хөгжүүлнэ.
- 1.2.5.3. Уламжлалт мал аж ахуйн гаралтай (тэмээний ноос, ямааны ноолуур) түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх аж ахуйг дэмжинэ.
- 1.2.5.4. Ингэ болон ямааны сүүгээр бэлтгэх цагаан идээг “брэнд” бүтээгдэхүүн болгон хөгжүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, соёл, уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, хүмүүнлэг, ёс зүйтэй, өв тэгш иргэнийг төлөвшүүлнэ.

2.1.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Политехник коллежийн сурагчдын сурлагын амжилт, гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1.1.1. Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг хэрэгжүүлнэ.
- 2.1.1.2. Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар ангид англи хэлний Pearson, математикийн Eduten хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суралцагсдад кодчилол, роботик болон хиймэл оюуны үр чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.1.1.3. Анги нийтийн аймгийн олимпиад зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг сайжруулан, анги хамт олны сурлагын амжилтыг үнэлж, дүгнэнэ.
- 2.1.1.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, удирдлага болон багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.2. Боловсролын байгууллагын барилга, байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлж, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг багасгана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.2.1. Баянгол суманд баригдаж буй 240 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Баян-Өндөр, Хархорин, Арвайхээр сумадад баригдаж буй тус бүр 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Арвайхээр сумын 150 хүүхдийн ортой 11 дүгээр (тусгай), Бүрд, Богд, Зүүнбаян-Улаан сумадад баригдаж буй тус бүр 50 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга болон өргөтгөлүүдийг барьж ашиглалтад оруулна.

2.1.2.2. Арвайхээр суманд 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга, Арвайхээр, Өлзийт, Бат-Өлзий, Хужирт сумдын сургуулиудад 100-160 ортой дотуур байрын барилга шинээр барьж ашиглалтад оруулна.

2.1.2.3. Баруунбаян-Улаан, Арвайхээр, Уянга, Есөнзүйл, Өлзийт, Гучин-Ус сумадад 50-150 ортой цэцэрлэгийн барилга шинээр барьж ашиглалтад оруулна.

2.1.2.4. Бат-Өлзий сумын 1 дүгээр сургууль, Хархорин сумын Номын хүрдэн сургууль, Баруунбаян-Улаан суманд тус тус 250 хүүхдийн суудалтай спорт заалны барилга шинээр барьж, ашиглалтад оруулна.

2.1.2.5. Ерөнхий боловсролын сургуулийг гадна биеийн тамирын талбайтай болгож, ерөнхий боловсролын сургууль, Политехник коллеж, цэцэрлэг, дотуур байр, спорт заалуудад их засвар хийнэ.

2.1.2.6. Ерөнхий боловсролын сургууль бүрийг дижитал технологид суурилсан “Ухаалаг анги”-тай болгож, сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, хатуу зөвлөн эдлэл, кабинетын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэн, камерын шинэчлэлийг хийнэ.

2.1.2.7. “Цөөн хүүхэдтэй анги”, “Гэрт ойр цэцэрлэг-хамгийн сайн цэцэрлэг” арга хэмжээг хэрэгжүүлж, Арвайхээр сумын алслагдсан багуудад “Сурагч автобус” явуулна.

2.1.3. Боловсролын бүх шатанд хүүхдийн хөгжил, хамгааллын орчинг сайжруулж, хүүхдийн сурч, хөгжих тэгш эрхийг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.1.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт “Сүү хөтөлбөрт” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.3.2. Бага насы (0-5 нас) хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, 1-2 насын хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг бий болгоно.

2.1.3.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч, хөгжихэд шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшах боловсон хүчнийг мэргэшүүлэн, нийгэм, хамт олонд нь түшиглэн сэргээн засах үйлчилгээг үзүүлнэ.

2.1.3.4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулна.

2.1.3.5. Суралцагсдын дундах үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, дотуур байрын хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг сайжруулж, орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулна.

2.1.3.6. Сургууль, цэцэрлэгийн гал тогооны эрүүл ахуйг стандартын шаардлагад нийцүүлэн, хүүхдийн хоолны шим тэжээл, илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.1.4. Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, боловсон хүчний нөөц, нийгмийн баталгааг хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1.4.1. “Багшийн тургуурт бодлого” цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.1.4.2. “Багш хөгжлийн ордон”-ыг шинээр байгуулж, Политехник коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг бүрд “Багш хөгжлийн танхим”-ыг бий болгоно.
- 2.1.4.3. Багш, удирдах ажилтны мэргэжил, арга зүйн тасралтгүй хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.4.4. Багш нарын ур чадвар, мэргэжлийг дээшлүүлэх, амжилт гаргасан багш нарыг урамшуулах зорилгоор 400 багшийг гадаад улсад богино хугацааны сургалт, арга хэмжээнд хамруулна.
- 2.1.4.5. Сумдад дутагдалтай байгаа математик, физик, хими, биологи, англи хэлний мэргэжлийн багшаар хангах бодлого хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуульд “Багш анги”-ийг хичээллүүлнэ.
- 2.1.4.6. Ерөнхий боловсролын сургуульд ажиллах сэтгэл зүйч, хоол зүйчдийг орон тоогоор ажиллуулна.

2.1.5. Сургалтын байгууллагуудын менежментийг сайжруулж, багш, удирдах ажилтны ёс зүйг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1.5.1. Ахлах сургууль байгуулах асуудлыг судалж, суралцагчдын сонирхол, хэрэгцээнд тулгуурлан төрөлжсөн сургалтын хөтөлбөрийг зарим сургуулиудад хэрэгжүүлж, орос, англи, япон, хятад, солонгос хэлний сургалттай анги, бүлгийг нээн, хичээллүүлнэ.
- 2.1.5.2. Багшийн ёс зүйг эрхэмлэн сахих, багшийн үнэлээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1.6. Иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйг дэмжин, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1.6.1. Насан туршийн боловсролын үндсэн чиглэлийг хөгжүүлж, албан бус сургалтыг зохион байгуулна.
- 2.1.6.2. Насан туршийн суралцахуйн төвүүдийн сургалтын техник, тоноог төхөөрөмжийг нэмэгдүүлэн, иргэд зайнаас суралцахад зориулан цахим интерактив хичээлийн орчин бүрдүүлнэ.
- 2.1.6.3. ESEL хөтөлбөр, өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох арга зүйг түгээн дэлгэрүүлж, нутагшуулна.
- 2.1.6.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүл иргэдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, суралцагч сум, баг, байгууллагыг дэмжин ажиллана.

2.2. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, нийт хүн амд эзлэх эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх замаар, аймгийн хүн амын дундаж наслалтыг улсын зорилтолт түвшинд хүргэнэ.

2.2.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.1.1. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх хангайн бүсийн дэд төвийг байгуулж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.1.2. Халдварт бус өвчинеэс сэргийлэх "Эрүүл Монгол" хөтөлбөрийг салбар дундын оролцоотойгоор хувь хүн, гэр бүл, байгууллага, аж ахуйн нэгжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

2.2.1.3. "Эрт илрүүлэг 2" арга хэмжээний хүрээг зорилтот бүлэгт чиглүүлж, эмчилгээ, хяналт, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.1.4. Өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.2. Эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх, иргэдийг орон нутагтаа өндөр өртөгтэй нарийн мэргэшлийн тусlamжийг авах боломжийг бүрдүүлснээр санхүүгийн болон цаг хугацааны хүлээгдэл чирэгдлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.2.1. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг ангиографийн зарим тоноог төхөөрөмжөөр ханган, хавдрын мэс заслын тусlamж, үйлчилгээг хөгжүүлж, төрөлжсөн эмнэлгүүдтэй хамтын гэрээ байгуулж, зарим өндөр зардалтай тусlamж, үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.2.2. Аймгийн хэмжээнд яаралтай тусlamж, перинатологийн төв, андрологи, герментлогийн нэгжийг тус тус байгуулна.

2.2.2.3. Уламжлалт, сэргээн засах тусlamж үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.2.2.4. Үндэсний эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд орох мэдээллийг олон улсын стандартын дагуу цуглуулж, түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.2.5. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоноог төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, худалдан авалт, үнийн бодлогын хэрэгжилтийг хангаж, эмийн зохистой хэрэглээг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.3.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ, худалдан авалт, ил тод байдлыг хангуулан, жорын талаарх нэгдсэн мэдээллийн санг бүрэн ашиглаж, эмийн эмчилгээний үр ашиг, үр дүнг тооцож ажиллана.

2.2.3.2. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, тандалт, судалгаа шинжилгээний ажлыг дэмжин, антибиотикийн зохистой хэрэглээнд хяналт тавина.

2.2.3.3. Бүсийн эм хангамж, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахыг байгуулж, үнэ, чанарын бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.2.3.4. Эрүүл мэндийн байгууллагуудад клиник эмнэлзүйн алба, нэгжийг бий болгоно.

2.2.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангарт, нийгмийн баталгааг сайжруулж, эрүүл мэндийн ажилтны чадамжид суурилсан бүтээмжийг тасралтгүй дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.2.4.1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангарт, хөгжил, нийгмийн баталгааг сайжруулах аймгийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.2.4.2. Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулиудтай хамтран ажиллах гэрээг байгуулж, орон нутагт эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг бэлтгэнэ.

2.2.4.3. Хархорин, Баянгол, Баруунбаян-Улаан, Өлзийт, Гучин-Ус, Төгрөг сумдын эмч нарыг нийтийн орон сууцаар, хөдөөгийн багийн төвд байнгын оршин суудаг эмч нарыг жижиг оврын автомашин, мотоциклоор үе шаттай хангана.

2.3.ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ

Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийг бууруулж, бие болоод сэтгэлзүйн хувьд эрүүл хүүхдийг төлөвшүүлэн, эх оронч үзэлтэй, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарласан, нийгмийн идэвхтэй шинэ үеийн залуучуудыг бэлтгэнэ.

2.3.1. Гэр бүлд ээлтэй, тэгш хүртээмжтэй цогц арга хэмжээг хэрэгжүүлж, түр хамгаалах байрны ая тухыг сайжруулан шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.1.1. Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зорилгоор “Халуун ам бүл” төслийг хэрэгжүүлнэ.

2.3.1.2. Эрүүл нийгмийг бүтээхэд эрчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний онцлог хэрэгцээ, тулгамдаж буй асуудлыг судлан тогтоож, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.3.1.3. Хохирогчийг түр хамгаалах байрыг засварлаж, мэргэжлийн хүний нөөцийг нэмэгдүүлнэ.

2.3.2.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх бодлогыг салбар дундын хамтын ажиллагаатай хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.2.1. “Хайлрагдсан хүүхэд” төслийг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.

2.3.2.2. Хүүхэд, өсвөр үеийнхнийг осол гэмтэлд өртөх, хорт зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, цахим орчны зохистой хэрэглээг бий болгох зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

2.3.2.3. Зүүнбаян-Улаан суманд хангайн бүсийн “Хүүхэд хөгжлийн зуслан”, Арвайхээр сумын ойролцоо хувийн хэвшилд түшиглэн “Гэр бүлийн зуслан”-г шинээр байгуулж, Уянга сум дахь хүүхдийн “Хөдөлмөр зуслан”-гийн үйл ажиллагааг дэмжих, өргөтгөнө.

2.3.2.4. Сум бүрд нийгмийн ажилтан ажиллуулна.

2.3.3.Залуучуудын бүх талын хөгжилд дэмжлэг үзүүлж, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.3.3.1. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.3.3.2. Залуучуудад гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Аз жаргалтай гэр бүл” сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, залуучуудын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 2.3.3.3. Зорилтот бүлгийн залуучуудыг хөгжлийн үйлчилгээнд хамруулах, “Залуусын боломж” явуулын үйлчилгээг нэвтрүүлж, хөдөөгийн залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.3.3.4. Төрийн бүх шатны байгууллага залуу албан хаагчдыг сургах, дадлагажуулах, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.3.3.5. Төр, иргэний нийгмийн болон зорилтот бүлгийн иргэд рүү чиглэсэн сайн дурын ажил, санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

2.4.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ

Үндэсний өв соёлоо хамгаалсан, эх, оронч үзэлтэй иргэнийг төлөвшүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын дархлааг бэхжүүлнэ.

2.4.1.Соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.4.1.1. Соёлын биет болон биет бус өвийг судлан шинжлэх, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.4.1.2. Дэлхийн өвд бүртгэгдсэн Төвхөн, Шанхын баруун хүрээ, Эрдэнэ Зуу соёлын өвийн цогцолборуудын хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.4.1.3. Аймгийн Ганданпунцоглин хийд орчмыг шашин, соёлын өв агуулгаар тохижуулж, Арвайн хүрээний Цогчин дуганыг хувийн хэвшил, иргэд, сүсэгтэн олны оролцоотойгоор шинээр байгуулан, аймгийн буддын шашин, соёлын төв болгон хөгжүүлнэ.
- 2.4.1.4. Аймгийн Музейн үзэл баримтлалд суурилсан үзүүллэг дэглэлтийн интерьер болон үзмэрүүдийг хийх хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, музейгээр дамжуулан соёлын олон талын үйлчилгээг олон нийтэд түгээнэ.
- 2.4.1.5. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлж, сумдад морин хуурын шавь сургалтыг зохион байгуулж, өсвөрийн морин хуур чуулгын үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2.4.2.Бүх нийтийн соёлын боловсролыг олгох үйл ажиллагааг орон нутгийн онцлогт тохируулан шинэлэг арга хэлбэр ашиглан хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.4.2.1. Үндэсний соёлын өв түүх, хэл соёл, ёс заншилд тулгуурлан “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.4.2.2. Иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор үндэсний мэргэжлийн урлагийн байгууллага болон шилдэг уран бүтээлчдийн уран бүтээлүүдийг орон нутагт урьж хамтран ажиллана.

2.4.2.3. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн, аймгийн Төв номын сангийн сан хөмрөгт жил бүр 10.0-аас доошгүй, сумдын Соёлын төвийн номын сангийн сан хөмрөгт 2.0-оос доошгүй сая төгрөгөөр баяжилт хийнэ.

2.4.3. Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны менежментийг сайжруулан хүний нөөцийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.4.3.1. Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийг сайжруулан, тоног төхөөрөмжөөр ханган ажиллана.

2.4.3.2. Дутагдалтай байгаа уран бүтээлчдийг орон нутагт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, хүний нөөцийн тогтвортой байдлыг ханган ажиллана.

2.4.3.3. Аймгийн Хөгжимт драмын театрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, менежментийг сайжруулан уран бүтээлчдийн ур чадвар, урын санг баяжуулна.

2.5.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Бүс нутгийн хөгжлийн онцлогт нийцүүлсэн ажлын байр бий болгож, нийгмийн хамгаалал, хөгжлийн үйлчилгээг зорилтот бүлгүүдэд оновчтой хүргэж, хүн бүрд ээлтэй орчин бүрдүүлэх бодлогыг баримтална.

2.5.1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах замаар 5000-аас доошгүй ажлын байр бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.1.1. Бүс нутгийн хөгжил, орон нутгийн бүтээн байгуулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах замаар ажлын байр бий болгоно.

2.5.1.2. Хөдөлмөр зуучлалын үйлчилгээг дэмжин цагийн ажлын тогтолцоог бий болгоно.

2.5.1.3. Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих бодлого баримтална.

2.5.1.4. Орон нутгийн төсвөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх 0,3 хувийн төсвийг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулж, гарааны бизнес, шинэлэг санал санаачилгыг дэмжин тогтвортой ажлын байр бий болгоно.

2.5.1.5. Эмэгтэйчүүд, жижиг дунд бизнес эрхлэгчдийг бойжуулан хөгжүүлж, олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар бизнесийн тогтвортой байдлыг үе шаттай хангана.

2.5.2.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нийцүүлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд 8000 иргэнийг хамруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.2.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг ганцаарчилсан болон болон бүлгийн зөвлөгөө мэдээлэл өгөх хэлбэрээр зохион байгуулна.

2.5.2.2. Политехник коллежийн суралцагчдыг орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан хөрвүүлэх, давтан сургах байдлаар зохион байгуулж, ажлын байранд зуучилна.

2.5.3.Хөдөлмөр нийгмийн гурван талт оролцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цалин хөлс, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.3.1. Хөдөлмөр нийгмийн гурван талт хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн маргаан таслах комиссын үйл ажиллагааг өргөжүүлэх, хөдөлмөрлөх эрхийн маргааныг шийдвэрлэнэ.

2.5.3.2 Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхжуулна.

2.5.3.3. Хувийн хэвшлийн байгууллагуудын хөдөлмөрийн харилцаа, цалин, хөлсний олголтод хяналт тавьж, үзлэг шалгалт, зөвлөн туслах, сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

2.5.4.Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чиглүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.4.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд хүргэх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

2.5.4.2. Хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлага хангасан зорилтот бүлгийн иргэдэд хүнс тэжээлийн дэмжлэгт үйлчилгээ үзүүлнэ.

2.5.4.3. Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэйгөөс бусад ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг ханггуулна.

2.5.4.4. Төр, төрийн бус байгууллагын түншлэл дээр тулгуурлан ахмад настны өдрийн асрамжийн үйлчилгээг хөгжүүлнэ.

2.5.4.5. Ахмадын сан, Ахмадын тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлэн, ахмадын насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг нэмэгдүүлнэ.

2.5.5.Хөгжлийн бэрхшээлийн талаарх зөв ойлголт эерэг хандлагыг төлөвшүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.5.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.5.5.2. Барилга байгууламж, орон сууц, нийтийн эзэмшлийн зам талбай, нийтийн тээвэр, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж стандартыг мөрдүүлнэ.

2.5.5.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг биеийн тамир, спорт, соёлын арга хэмжээнд оролцуулахад дэмжин, аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг салбар дундын уялдаатай зохион байгуулна.

2.5.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулан, дэмжин ажиллана.

2.5.6.Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.5.6.1. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг ил тод түргэн шуурхай хүртээмжтэй хүргэнэ.
- 2.5.6.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- 2.5.6.3. Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх талаар териин болон териийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.

2.6.БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Биеийн тамир, спортыг хүн амын амьдралын хэв маяг, амьдралын чанарыг дээшлүүлэх хэрэглүүр болгож, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулан, бүх түвшинд тамирчдын ур чадварыг ахиулж, тив, дэлхий, олимпод өрсөлдөхүйц чадварыг нэмэгдүүлнэ.

2.6.1.Хүн амыг идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэж, эрүүл мэндээ дэмжихэд чиглэсэн олон талт орчин нөхцөл, боломжоор хангаж, нийтийн биеийн тамирын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн бие бялдарын хөгжил, боловсролыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.6.1.1. Иргэдийг эрүүл чийрэг, бүтээлч зан чанарыг эрхэмлэсэн өдөр тутмын дасгал хөдөлгөөн, зөв хооллолт, эрүүл амьдралын хэв маяг бүхий дадалд сургаж, шинэ санал санаачилгыг дэмжин хамтран ажиллана.
- 2.6.1.2. Сумдыг биеийн тамирын орон тооны арга зүйчтэй болгож, бүх нийтийн биеийн тамирын арга хэмжээнд оролцогчдын тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хамрах хүрээг өргөжүүлнэ.
- 2.6.1.3.Усан бассейныг мэргэжлийн багш дасгалжуулагч, төхникчийн орон тоогоор хангаж, багш дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлнэ.

2.6.2.Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим өгөгдлийн санг бий болгож, орон нутгийн биеийн тамир, спортын салбарын нэгдсэн статистик мэдээллийн баазыг үүсгэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.6.2.1.Хүн амыг “Бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-д хамруулах сорилын зориулалтын өрөөг байгуулж, иргэд, олон нийтийг сорилд хамруулах ажлыг тогтмолжуулна.
- 2.6.2.2.Сорилд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийг боловсронгуй болгож, биеийн тамир, спортын салбарт хамаарах статистик тоон мэдээллийг нэгтгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.6.3.Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг нээн илрүүлж, шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэх спортын сургалт-дасгалжуулалтын шаталсан тогтолцоог боловсронгуй болгож, тамирчдын өрсөлдөх чадварыг ахиулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.6.3.1. Өсвөр үеийн шигшээ багийг жүдо бөх, чөлөөт бөх, таеквондо, хүндийн өргөлт, волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөг, шатар, цана, ширээний теннис, усанд

сэлэлтийн спортын төрлүүдээр мэргэжлийн спорт клубүүдийг түшиглэн байгуулж, дэмжинэ.

2.6.3.2. Нэрэмжит болон улсын чанартай 4 хүртэлх тэмцээнийг жил бүр орон нутагтаа зохион байгуулна.

2.6.3.3. Спортын авьяасыг нээн илрүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөгжих боломжийг олгох зорилгоор спортын материаллаг баазыг бүрдүүлж, хэрэглэл материалыар хангана.

2.6.4.Стандартад нийцсэн заал, талбай, дэд бүтцийг төрөлжүүлэн барьж байгуулан биеийн тамир, спортын үйл ажиллагаанд тогтмол, тасралтгүй хамрагдан хичээллэх орчин, нөхцөлөөр хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.6.4.1.Спорт ордны Б зааланд их засвар хийж, гадна талбай, машины зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлж, Арвайхээр сумын 10, 11 дүгээр багийн нутаг дэвгэрт, Богд суманд спорт заал шинээр барьж ашиглалтад оруулна.

2.6.4.2. Арвайхээр хотын шинэ наадмын талбай байгуулах, хуучин наадмын талбайг шинэчлэн спорт-соёлын цогцолбор (UV-Arena) болгох ажлын хэсэгчилсэн төлөвлөгөөг тус тус хийлгэж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

2.6.4.3. Усан спорт, сургалтын төвийн бассейн, фитнесийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, боулингийн төвийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.ТӨСӨВ САНХҮҮ

Төсөв санхүүгийн үйл ажиллагааг технологийн дэвшлийг ашиглан үр ашигтай удирдан, орон нутгийн өмчит компаниудын үр өгөөжийг нэмэгдүүлж, төрийн бүх шатанд төсвийн сахилга хариуцлагыг сайжруулна.

3.1.1.Орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, үр ашиггүй зардлыг бууруулах замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.1.1. Орон нутгаас тогтоож буй албан татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоож, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг үр дүнд суурилан төлөвлөж, гүйцэтгэлийг хангана.

3.1.1.2. Далд эдийн засгийг салбар бүрээр тодорхойлж, төлбөрийн баримт олголтыг эрчимжүүлэн тухайн салбарын татвар төлөгчдөд тохирсон үйлчилгээг үзүүлэх замаар татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.

3.1.1.3. Иргэн, аж ахуйн нэгжийн татварын боловсрол, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг сайжруулах замаар татварын бааз суурийг нэмэгдүүлэн, татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлнэ.

3.1.1.4. Эрсдэлийн үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах цахим системийг бүтээж, бүх шатны хяналт шалгалт, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг эрсдэлд суурилсан байдлаар төлөвлөж, зохион байгуулна.

3.1.2.Орон нутгийн өмчит компаниудын засаглалын менежментийг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.2.1. Орон нутгийн өмчит зарим хуулийн этгээдийг хувьчлах, нэгтгэх бодлого баримтлан засаглалын менежментийг сайжруулж, алдагдлыг бууруулна.

3.1.2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод, нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.

3.1.2.3. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарын бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжинэ.

3.1.3. Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарыг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.3.1. Өмнөх гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй аж ахуйн нэгжийг тендерт оролцсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болгоно.

3.1.3.2. Тендерт оролцсон аж ахуйн нэгж гэрээний үүргээ удаа дараа чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тендерт оролцох эрхийг хязгаарлуулна.

3.1.3.3. Тендерт оролцож шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээний үүргээ бусдад шилжүүлэхийг хориглох талаар гэрээнд тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

3.1.4. Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.1.4.1. Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, хэрэгжүүлэн ажиллана.

3.1.4.2. Төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим системээр дамжуулан олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.4.3. Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангана.

3.2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулан мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж, газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.1. Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.1.1. “Баянгол омог”-ийн хонин сүргийг “Баянгол үүлдэр” болгох, Гучин-Ус сумын Монголын хоолойн тэмээ, Нарийнтээл сумын Тээлийн улаан ямаа, Уянга сумын нутгийн шилмэл сарлаг, үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны ажлыг үргэлжлүүлж, үүлдэр, омог, хэвшлийн малыг баталгаажуулна.

3.2.1.2. Үхэр, тэмээ болон өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малыг эдийн засгийн эргэлтэд оруулан тоо толгойгоос чанарт шилжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.2.1.3. Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийг сумдад байгуулж, цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна.

3.2.1.4. Махны чиглэлийн үхэр болон туслах аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, төвлөрсөн хот, суурин газрын хүн амын махны хэрэгцээг хангана.

3.2.1.5. Малын тоо толгойн албан татварыг сумдын бэлчээрийн даац, малын төрөл, сүргийн бүтцийг харгалзан тэнцвэртэй байдлаар тогтоох бодлого баримтална.

3.2.1.6. Залуу малчдад сайн малчны тэргүүн туршлагыг сурталчлан таниулах, тэднийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, малчдыг чадавхжуулна.

3.2.2.Бэлчээр ашиглалт, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.2.1. Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

3.2.2.2. Бэлчээрийг усжуулах, сэлгэж өнжөөх, хортон мэрэгчдээс хамгаалах зэргээр ашиглалтыг сайжруулна.

3.2.3.Малчдын хоршоог чадавхжуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.3.1. “Шинэ хоршоо-хөдөлгөөн”-ийг аймгийн хэмжээнд үргэлжлүүлэн өрнүүлж, малчдын хоршоодод хөнгөлөлттэй зээл олгох, малын гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоог сайжруулна.

3.2.3.2. Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж, хоршооны загвар төслүүдийг бэлтгэж, малчдад зөвлөн туслах үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэн, сургалт зохион байгуулна.

3.2.4.Мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний түвшинг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт, өвчинеөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдвартгүй өвчний өвчлөлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.4.1. Орон нутгийн төсвийн зардлаар хийгддэг дотрын халдарт хордлого, цусан халдварт, дуут хавдар, энтеробактериоз, гахайн цусан халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.

3.2.4.2. Арвайхээр, Нарийнтээл, Хархорин, Хужирт, Бат-Өлзий зэрэг сумдын үхэр сүргийг бруцеллёзын халдвартгүй болохыг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд сумын түвшинд лабораторийн анхан шатны шинжилгээ хийж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

3.2.4.3. Мал эмнэлгийн салбарын боловсон хүчний мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, салбарын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.4.4. Мал, эмнэлгийн лабораторийн багаж оношуулур, вакцин хадгалах, тээвэрлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх техник, тоног төхөөрөмжөөр хангана.

3.2.5.Орон нутгийн хүн амын хэрэгцээт үр тариаг 90 хувь, хүнсний ногоог 35 хувь, төмсийг 100 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.2.5.1. Газар тариалангийн эргэлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэн, ашиглалтыг сайжруулж, тариаланчдыг үр, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт хамруулах замаар

стратегийн хүнсний зориулалттай болон бусад нэр төрлийн ашигт таримлын тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.5.2. Хужирт, Тарагт, Арвайхээр сумдын услалтын системийг сэргээн засварлаж, Баруунбаян-Улаан, Хархорин сумдын услалтын системийн зураг төсөв хийлгэх, бусад сумдад хөв цөөрөм байгуулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.2.5.3. Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, нарийн ногооны дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

3.2.5.4. Арвайхээр, Хархорин сумдад бүрэн автомажсан хүнсний ногооны төрөлжсөн зоорь, Бүрд, Сант сумдад төмсний зоорийг тус тус байгуулна.

3.2.5.5. Арвайхээр, Төгрөг, Баруунбаян-Улаан, Хархорин сумдад агро-ойн аж ахуй байгуулан, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2.5.6. Тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор хамгаалалтын ойн зурvas байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

3.2.5.7. Сумдад атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

3.2.5.8. Хөдөө аж ахуйн техник дундын төв болон түрээсийн аж ахуй байгуулах санал, санаачилгыг дэмжин, сумдад техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар механикуулалтын хувийг нэмэгдүүлнэ.

3.3.ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ:

Үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, дотоодын үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлнэ.

3.3.1.Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.3.1.1. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хүрээнд арьс шир, ноос, ноолуур зэрэг малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжинэ.

3.3.1.2. Арвайхээр суманд бүсийн үйлдвэр технологийн парк байгуулж, орон нутгийн итгэмжлэгдсэн лабораториудыг чадавхжуулж, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлнэ.

3.3.1.3. Дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех байгуулахад дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд нийлүүлнэ.

3.3.1.4. "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өрнүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлнэ.

3.3.1.5. Үйлдвэрийн аргаар төхөөрч, бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих замаар махны үйлдвэр, мал төхөөрөх цехүүдийн үйл ажиллагааг тогтвортжуулна.

3.3.1.6. Томоохон сумдын Засаг даргын Тамгын газрыг хүнс, худалдаа үйлчилгээний улсын байцаагчтай болгож, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг жил бүр батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж, эрсдэлд сууриссан хяналт шалгалтыг төлөвлөн зохион байгуулна.

3.3.1.7. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.

3.4.НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, байгаль орчны тогтвортой байдлыг хадгалан хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.1. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах нөхөн сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.4.1.1. Гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, усан сан бүхий газрыг нөхөн сэргээх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.4.1.2. Төв суурин газрын ундны усны нөөцийн судалгааг хийлгэж, усны чанар, аюулгүй байдлыг хангана.
- 3.4.1.3. Усны хэрэглээ, ашиглалтын хэмнэлтийг бий болгож, дахин ашиглалтыг дэмжинэ.
- 3.4.1.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 3.4.1.5. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойжуулалт, ойн зурvas байгуулах ажлыг зохион байгуулна.
- 3.4.1.6. Олон улсын төсөл хөтөлбөртэй хамтарч мод бут тарих, мод үржүүлгийн газрыг чадавхжуулах болон иргэд олон нийт, ёсвэр үеийнхэнд экологийн боловсрол олгоно.
- 3.4.1.7. Нэн ховор, ховор амьтдын амьдрах орчныг сайжруулж, хамгаалалтын арга хэмжээ авна.

3.4.2. Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулж, ногоон үзэл санаа, дадлыг нэвтрүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.4.2.1. Аймгийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.4.2.2. Дэд бүтцийн хөгжилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулна.
- 3.4.2.3. Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтолжуулан ган хуурайшилтын эрсдэлийг бууруулна.
- 3.4.2.4. Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.

3.4.3. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.4.3.1. Орхон голын сав, хангайн нурууны экосистемд түшиглэсэн түүх, соёл, рашаан сувиллын аялал жуулчлалыг хөгжүүлж, Төвхөн хийдийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан угтах орчныг тохижуулна.
- 3.4.3.2. Өндөр гэгээн Занабазарын үйл хэргийг мөнхжүүлэх болон эртний нийслэл Хархорум-Эрдэнэзуу хийдийг түшиглэсэн соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгоно.
- 3.4.3.3. Аялал жуулчлалын гол чиглэл дагуу дэд бүтцийг хөгжүүлж, үйлчилгээний байгууллагуудыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 3.4.3.4. Монголын нүүдлийн соёл, түүх болон орон нутгийн онцлогт тохирсон эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

3.4.3.5. Аймгийн аялал жуулчлалын бүсийг шинэчлэн тогтоож, менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлнэ.

3.4.3.6. Монгол Улсын төв цэгийг түшиглэсэн аялал жуулчлалын цогцолбор бий болгоно.

3.4.4. Байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.4.4.1. Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажлыг дэмжиж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

3.4.4.2. Эрдэс баялгийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтэд мэдээллийн ил тод байдлыг хангана.

3.4.4.3. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлөвлөгөөт нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтээр хийнэ.

3.4.4.4. Уул уурхайн ашиглалтын улмаас эвдэрч, орхигдсон, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй газруудын нөхөн сэргээлтийг олон улсын төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн байгууллагуудын нийгмийн хариуцлага, төрийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэнэ.

3.4.4.5. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлд үнийн хөөрөгдлийг бууруулах, өрсөлдөөнийг дэмжих зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.4.4.6. Орон нутгийн өмчит Баянтээг хувьцаат компанийн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай хийж, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

3.5. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Аймгийн хэмжээнд сумдын төв болон газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

3.5.1. Сумдын инженерийн шугам сүлжээний бие даасан дэд бүтцийг бий болгох, иргэдийн орон нутагт ажиллаж, амьдрах ая тухтай орчинт бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.5.1.1. Сант, Богд, Баянгол сумдын усан хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийг засварлаж, хэвийн үйл ажиллагааг хангана.

3.5.1.2. Уянга, Бат-Өлзий, Хужирт, Нарийнтээл сумдын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийн ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.

3.5.1.3. Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Баян-Өндөр, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Зүүнбаян-Улаан, Тарагт, Төгрөг сумдыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй болгох зураг төслийг гүйцэтгүүлж, ажлыг эхлүүлнэ.

3.5.1.4. Хархорин сумын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ.

3.5.1.5. Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй технологиор гэр, амины орон сууцны халаалтаа шийдвэрлэсэн айл өрх, мөн уг технологиор амины болон нийтийн орон сууц шинээр барих иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

3.5.1.6. Сумдын дулааны шугам сүлжээг үе шаттайгаар өргөтгэж, гэр хорооллын айл өрхүүдийг холбоно.

3.5.2.Арвайхээр хотын дулаан хангамжийн нэгдсэн эх үүсвэрийг бий болгож, агаарын бохирдлыг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.5.2.1. Дулааны 30 МВт хүчин чадалтай станцыг барьж, ашиглалтад оруулна.
- 3.5.2.2. Дулаан дамжуулах төвүүд болон дулааны станцын гадна цахилгаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбоожуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.5.2.3. Дулааны станцын 2 дугаар конторын шугам сүлжээг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 3.5.2.4. Шинээр төлөвлөгдсөн орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцийн зураг төслийг гүйцэтгүүлж, ажлыг эхлүүлнэ.
- 3.5.2.5. Гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр, бохир, дулааны шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- 3.5.2.6. Шахмал түлшийг үйлдвэрлэж, гэр хорооллын айл өрхүүдийг үе шаттай хангана.

3.5.3.Ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлж, орон нутагт ажиллаж, амьдрах тав тухтай орчинг бий болгоно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.5.3.1 Сумдын төвүүд доторх хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн зам, гэрэлтүүлгийг өргөтгөн, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, засвар арчлалт, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийнэ.
- 3.5.3.2. Арвайхээр сумын төвийн хэсэг, Онгийн гол дагуух усан хангамжийн эх үүсвэрүүдийг үерээс хамгаалах зорилгоор урсац тохируулгын усан сан, далан байгуулна.
- 3.5.3.3. Сумын төвийн эрчим хүчний уналттай газруудад дэд станц, шугам сүлжээг өргөтгөнө.
- 3.5.3.4. Орон нутгийн чанартай автозам, гүүрүүдийн засвар арчлалтыг жил бүр хийж, Арвайхээр, Хужирт, Бат-Өлзий, Уянга, Нарийнтээл сумдын үерийн далангийн ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.

3.6.ГАЗРЫН ХАРИЛЦАА

Хүн амын амьдрах орчин сайжирч, эдийн засагт хэмнэлттэй, үр өгөөжтэй, зөв төлөвлөлттэй хотыг бий болгоно.

3.6.1.Аймгийн хэмжээнд газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж, газар олголтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 3.6.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 15 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.6.1.2. Зүүнбаян-Улаан, Бүрд, Есөнзүйл, Баян-Өндөр, Тарагт, Баруунбаян-Улаан, Өлзийт сумдын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгүүлнэ.
- 3.6.1.3. Арвайхээр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, 3 дахь шинэ суурьшлын болон үйлдвэрлэлийн бүсэд хэсэгчилсэн төлөвлөлт хийлгэнэ.
- 3.6.1.4. Төв суурин болон улсын чанартай зам дагуух газруудад хэсэгчилсэн төлөвлөлт хийлгэж, иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.6.1.5. Аймаг болон сумын төвүүдэд нийтийн орон сууцны зориулалттай газруудыг орон нутгийн хэрэгцээнд авч, иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцаар хангах теслүүдийг хэрэгжүүлж, гэр хороолол болон хуучин орон сууцнуудыг дахин төлөвлөлтөд оруулна.

ДӨРӨВХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1.ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Хууль нэг мөр хэрэгждэг, хүний эрхийг дээдэлсэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх замаар ихэвчлэн үйлдэгдэг гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулна.

4.1.1.Төрийн бүх шатны байгууллага шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон, төрийн байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээний дундаж үзүүлэлтийг 80 хувьд хүргэнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.1.1. Нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд жендер, хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийн зөрчил гаргахгүй байх хяналтыг өргөжүүлнэ.

4.1.1.2. Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, цахим технологи ашиглан нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлж, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.

4.1.1.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, бүх нийтээр авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.2.Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэн, жендерийн мэдрэмжтэй нийгмийн орчинг бүрдүүлж, цаашид гарч болох жендерт суурилсан хүчирхийллийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.2.1. Хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг сайжруулах замаар чанартай, урт наслалтыг дэмжинэ.

4.1.2.2. Эрэгтэйчүүдийн нас, эрхэлж буй ажил, салбарын онцлог, амьдарч буй байршил зэргийг харгалзан зам тээврийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахим орчинд тасралтгүй түгээж, иргэд олон нийтийн хандлагыг өөрчлөх арга хэмжээг бүх шатанд зохион байгуулж, хэвшүүлнэ.

4.1.2.3. Төрийн байгууллагуудад жендерийн тэнцвэртэй байдлыг хангах үзэл баримтлалыг нэвтрүүлж, иргэдэд жендерийн мэдрэмжтэй төрийн үйлчилгээг хүргэнэ.

4.1.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлж, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг судлан тогтоох арга зүйг шинэчилж, нутаг дэвсгэрийн хэмжээнд ихэвчлэн үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог үе шаттай бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.3.1. Гэмт хэрэг үйлдэгдэх шалгаан нөхцөлийн судалгааг сум тус бүрээр шинэчлэн хийж, судалгаанд тулгуурласан урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнд хүрэхүйц байдлаар үе шаттай зохион байгуулна.

4.1.3.2. Аймаг, сумын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, улсын болон орон нутгийн чанартай замын хяналтыг сайжруулж, теле-камерын тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.3.3. Хууль, хяналтын салбарын алба хаагчдыг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлж, ажлын үр дүнд суурилсан урамшуулал, сахилга хариуцлага, харилцаа хандлагыг сайжруулж, ажлын үр дүнг дээшлүүлнэ.

4.1.3.4. Архидан согтуурахтай тэмцэх, архины хор хөнөөлийг нийгэмд таниулах төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллана.

4.1.4.Хууль сахиулах болон зарим хяналтын байгууллагуудын ажлын байр, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.1.4.1. Төрийн архив, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгыг шинээр барьж, төрийн архив, сан хөмрөг, лавлагаа мэдээллийн цахимжуулалтыг эрчимжүүлж, үйлчилгээг хялбарчилна.

4.1.4.2. Цагдаагийн газарт эрүүлжүүлэх, saatuulaх байр, Бат-Өлзий суманд цагдаагийн тасгийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.

4.1.4.3. Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга, Шүүхийн шинжилгээний бүсийн төвийн стандартад нийцсэн шинэ барилгыг тус тус барьж, лабораторын тоног төхөөрөмж, хэргийн газрын үзлэг шинжилгээний техник хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.1.4.4. Дотоодын цэргийн хамгаалалтад Эрдэнэзуу хийд, Арвайхээр хотын дулааны станцыг авах, дотоодын цэргийн байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна.

4.2.ТӨРИЙН БҮТЭЭМЖ-ЦАХИМ ЗАСАГЛАЛ

Дэвшилтэт технологид тулгуурлан төрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг дэмжиж, шинэ технологи инновацийг нутагшуулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.1.1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн аймгийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

4.2.1.2. Жил бүр аймгийн тулгамдаж буй асуудлаар эрдэм шинжилгээ болон онол практикийн бага хурлыг зохион байгуулж, үр дүнг үйл ажиллагаандaa тусган хэрэгжүүлнэ.

4.2.1.3. Хөдөө аж ахуйн туршилт, судалгаа, малын үржил селекцийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг хийлгэж, ашиглалтад оруулна.

4.2.1.4. Гарааны бизнес эрхлэгчдийн дунд шинэ технологи, инновацийд суурилсан төслийн уралдаан зарлаж, шилдэг бүтээлүүдийг дэмжинэ.

4.2.2.Мэдээллийн технологи, харилцаа холбооны дэд бүтцийг өргөтгөж, цахим шилжилтийг эрчимжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.2.2.1."Цахим жишиг аймаг" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн "Go Uvurkhangai" аппликашн, системүүдийг үйл ажиллагааг жигдрүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 4.2.2.2.Орон нутгаас үзүүлж буй төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах процессын дахин инженерчлэл хийж, үйл ажиллагаа, үйлчилгээг хялбаршуулах, цахимжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.2.2.3.Харилцаа холбооны дэд бүтэц, үүрэн холбооны сүлжээг алслагдсан багуудад өргөтгэж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.2.2.4.Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, кибер аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийлгэж, зөрчлийг арилгуулна.
- 4.2.2.5. Мэдээлэл технологийн мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, чадавхжуулан бүх нийтэд цахим ур чадвар олгох сургалтыг үе шаттай зохион байгуулна.

4.2.3. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын ил тод байдлын түвшин, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.2.3.1. Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 4.2.3.2. Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэх процессыг хялбаршуулж, шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, тухайн байгууллага, албан тушаалтны ажлын үр дүнг тооцдог болно.
- 4.2.3.3. Нийгмийг соён гэгээрүүлэх, төрийн байгууллагаас гарч буй шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд хүртээмжтэй хүргэх ажлыг иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

4.2.4. Орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.2.4.1. Есөнзүйл, Богд сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд, Нарийнтээл, Уянга, Хужирт, Хархорин, Зүүнбаян-Улаан, Бүрд, Өлзийт, Сант сумдын Засаг даргын Тамгын газрын барилгын урсгал засварын ажлыг гүйцэтгэнэ.
- 4.2.4.2. Баг, хорооны үйл ажиллагааны зардлын нормативыг шинэчлэн, сумын төсөвт тусгайлан баталж, сум, багийн Засаг дарга нарыг унаагаар хангаж, төрийн байгууллагуудын техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилнэ.

4.2.5. Төрийн байгууллагаас гарч буй бодлого шийдвэрийн төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 4.2.5.1. Үр дүнд суурилсан төлөвлөлт, хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн системийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 4.2.5.2. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааг тогтмолжуулж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний орон нутгийн чадавхыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.5.3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад хувийн хэвшил, иргэний оролцоот хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2.6.“Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.6.1. Франц, Итали, Герман, Япон, Польш, Турк зэрэг орнуудын ижил түвшний байгууллага, хот, мужуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх болон шинээр тогтооно.

4.2.6.2. Аймгийн салбар бүрийн албан хаагчдыг гадаад улс оронд жил бүр сургах, дадлагажуулах, харилцан туршлага солилцох, гадаадаас нарийн мэргэжилтэй боловсон хүчнийг урьж харилцан туршлага солилцох үйл ажиллагаа явуулна.

4.2.6.3. Хамтын ажиллагаатай гадаадын байгууллага, хот, мужуудтай эдийн засаг, нийгмийн салбарт хөрөнгө оруулахуйц үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.7.Олон улсын байгууллагуудтай эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, төслийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.7.1. Олон улсын донор байгууллагуудад нийгмийн шинж чанартай төслийн саналуудыг илгээж, дэмжлэг авна.

4.2.7.2. Өрхийн үйлдвэрлэл, гарааны, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлийн олон улсын төслүүдэд иргэд, төрийн бус байгууллагуудыг хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

4.2.7.3. Бус, орон нутгийн хөгжилд түлхэц үзүүлэхүйц дэд бүтцийн томоохон төслүүдийг олон улсын хандивлагч байгууллагуудад хүргүүлж, үр өгөөжтэй хөрөнгө оруулалтыг татна.

4.2.8.Уламжлалт харилцаатай Бүгд Найрамдах Солонгос улс, Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улстай олон талт хамтын ажиллагааг эрчимжүүлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.2.8.1. Хамтын ажиллагаатай Бүгд Найрамдах Солонгос Улсын Чэжу аймаг, Ансан зэрэг хотуудтай боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны чиглэлээр хамтарч ажиллана.

4.2.8.2. БНХАУ-ын хамтын ажиллагаатай хот мужуудтай хөдөө аж ахуй, хот байгуулалт, жижиг дунд үйлдвэрийн технологи нутагшуулах, мэргэжилтэн солилцох чиглэлээр хамтарч ажиллана.

4.2.8.3. Оросын Холбооны Улсын Красноярск мужийн Агаар их сургуультай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлнэ.

4.2.8.4. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, хог хаягдлыг боловсруулах, барилга, зам тээврийн салбарт хөрөнгө оруулалтын хурал зөвлөгөөнийг гадаад түнштэй хамтарч зохион байгуулж, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

4.3.ОРОН НУТГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ

Чадахуйн зарчимд суурилсан ёс зүйтэй, мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлнэ.

4.3.1.Хүний нөөцийн бодлогыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.1.1.Төрийн байгууллагуудыг боловсон хүчинээр хангах хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж, шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудад суралцах хугацааны төлбөрийн хөнгөлөлт үзүүлж, орон нутагт гэрээгээр ажиллуулна.

4.3.1.2. Төрийн үйлчилгээний байгууллагын гүйцэтгэх албан тушаалын сүл орон тоог олон нийтэд мэдээлж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж хэвшилжүүлнэ.

4.3.1.3. Төрийн албаны ерөнхий шалгалтын явц, үйл ажиллагааг олон нийтийн сувгаар шууд дамжуулалт хийж, нээлттэй ил тод болгоно.

4.3.1.4. Байгууллагын удирдлагын хүний нөөцийн шийдвэрт хяналт шалгалт хийж, зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хууль бус томилгооны зөрчлийг арилгуулна.

4.3.2.Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлж, чадавхыг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.2.1.“Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.3.2.2. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор төрийн албанд 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 3 жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг “1+2” буюу гадаадад хэлний болон мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна.

4.3.2.3. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг бодитой үнэлж, “маш сайн” үнэлэгдсэн төрийн захиргааны албан хаагчдад байгууллагын зүгээс сургалтын төлбөрийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэн төрийн албаны сургалтын байгууллага болох Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулна.

4.3.2.4 Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг бодит болгож, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.3.2.5. Сумдад төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлөөр төрийн албан хаагчдад зориулсан орон сууц барина.

4.3.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийг бууруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.3.3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3.3.2.Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

4.3.3.3. Төрийн байгууллагын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, ёс зүйн дэд хорооны ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тогтвортой ажиллах хөшүүрэг болох урамшууллыг олгоно.

4.4.ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэлжилтийг дээшлүүлж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлнэ.

4.4.1.Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудын цэрэг-эх оронч үзлийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

4.4.1.1. Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бэлэн байдлыг хангаж, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг тогтмолжуулан, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх замаар Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бодлогыг орон нутагт түгээн дэлгэрүүлнэ.

4.4.1.2. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулж үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх замаар орон нутгийн аюулгүй байдлыг хангах бөгөөд сумдын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн баталж, хяналтыг сайжруулна.

4.4.1.3.Уянга суманд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах бүлэг, Гучин-Ус суманд улсын нөөцийн цэг байгуулж, үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.4.1.4.Сумдын гамшиг хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг чадавхжуулж, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэлжилтийг сайжруулж, олон нийтэд урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн арга хэмжээний хүртээмжийг дээшлүүлнэ.

4.4.1.5.Төр, Улаан загалмайн хамтын ажиллагааны нэгдмэл байдлыг зохион байгуулж, төрийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.

-----oOo-----